Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

410. Гуурсан хоолойн багтрааны эмчилгээнд дараах зүйлс цээртэй

1. Чанга дуу чимээ, хурц гэрэл, зурагт удаан үзэх

2. Хүйтэн ундаа, амтлагч, янз бүрийн халуун ногоо, мөхөөлдөс

3. Хүйтэн цочир даарах, хэт халууцах

4. Давс, чихэрлэг зүйлс түлхүү хэрэглэх

5. Идэвхитэй хөдөлгөөн хийх

А. Бүх хариулт зөв бол

В. Зөвхөн 4-р хариулт зөв бол

С. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Д. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

Е. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

411. Ханиалгаж буй хүүхдэд ямар шинж илрэхэд уушгины хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин гэж ангилах вэ?

1. Ямар нэг аюултай ерөнхий шинж.

2. Цээж хонхолзох.

3. Тайван үедээ хяхтнаж амьсгалах.

- 4. Амьсгал олшрох.
- 5. Амьсгал шуугиантай байх.
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

412. Дутуу нярай уушгинд юу дутагдсанаас цулцангийн авчилз үүсч амьсгалын дутагдалд ордог вэ?

- 1. O₂
- 2. CO₂
- 3. Цус
- 4. Сурфактант
- 5. Ус
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

413. Хэрлэгийн оношлогооны Кисель- Джонсоны эмнэлзүйн туслах шалгуурт орох шинжүүдийг сонгоно уу.

- 1. Хэрлэгээр өвдөж байсан өгүүлэл
- 2. Үеэр хэрж өвдөх, халуурах
- 3. Ядрах, хэвлий өвдөх, хамраас цус гарах
- 4. Цагираг хэлбэрийн тууралт
- 5. Арьсан доорх зангилаа
- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

414. Хамрын дайвар хөндийнүүдийн үрэвсэл байж болзошгүй өвчтөнд өрхийн эмчээс ямар тусламж үзүүлэх вэ?

- 1. Дайвар хөндийн зураг авахуулна.
- 2. Чих хамар хоолойн эмчид үзүүлнэ.
- 3. Чих хамар хоолойн эмчийн зөвлөмжийг биелүүлнэ.
- 4. Давтан үзлэг товлон.
- 5. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг хэлж өгнө.
- A. Бүх хариулт зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

415. Аль шалтгааны улмаас хүүхэд амархан гулгидаг вэ?

- 1. Ходоодны амсрын сфинктер булчингийн хөгжил сул
- 2. Нугалуурын булчин сайн хөгжсөн

3. Ходоод ташуу байрлалтай
4. Хүүхдийн биеийн гадаргуугийн масс бага
5. Ходоодны агшилт муу
- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. Бүх хариулт зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

416. Зүрхний дутагдлын 2а үед илрэх эмнэлзүйн шинжүүдэд дараах орно

1. Тайван үед амьсгаадах
2. Уушгины доод хэсэгт нойтон хэржигнүүртэй
3. Гүрээний вен чинэрэх
4. Элэг томрох
5. Хөлийн шилбээр хавагнах

- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

417. Зүрхний булчингийн үрэвслийн үед эмнэлзүйд илрэх гол шинжүүдийг дурьдана уу.

1. Зүрх зүүн тийш томрох
2. Зүрхний оройд агшилтын шуугиан
3. 1-р авиа бүдгэрэх
4. 1-р авиа эрс тодрох
5. Зүрхний цохилт цөөрөх

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

418. Шээсээр оксалат их гарч байгаа хүүхдэд дараах хүнсний бүтээгдхүүнийг зөвлөнө:

1. Байцаа
2. Чангаанз
3. Гадил, лийр
4. Ургамлын тос
5. Цагаан талх

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

419. Маш хүнд халууралт өвчнийг ямар шинжүүдээр ангилах вэ?

1. Аюултай ерөнхий шинжийн аль нэг илрэх.
2. 40 хэмээс дээш халуурах.

3. Хүзүү хөшингө болох.
 4. 38,5 дээш халуурах
 5. Эм уухдаа бөөлжих.
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
E. Бүх хариулт зөв бол

420. Уушгины хатгалгаатай 6 сартай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь янзандаа, ханиалгасан хэвээр, амьсгал минутанд 52 байв. Ямар арга хэмжээ авах вэ?

1. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.
 2. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 4. 2 хоноод давтан үзнэ.
 5. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- A. Бүх хариулт зөв бол
B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

421. Хөврөлийн хөгжлийн хэд дэх долоо хоногт зүрх үүсч эхэлдэг вэ?

1. 1 дэх долоо хоног
 2. 5 дэх долоо хоног
 3. 6 дэх долоо хоног
 4. 2 дэх долоо хоног
 5. 81 дэх долоо хоног
- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
D. Бүх хариулт зөв бол
E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

422. Ховдол хоорондын таславчийн цоорхойд хамааралтай тодорхойлолтыг зөв сонгоно уу.

1. Зүрхний төрөлхийн гажгуудын дотор хамгийн олонтаа тохиолддог гажгуудын нэг юм
 2. Цус эргэлтийн өөрчлөлт нь зүүн ховдлоос баруун руу юүлэгдэнэ.
 3. Цус эргэлтийн өөрчлөлт 2-4 сараас эхлэн ажиглагдана
 4. Хөхрөх шинж бүхий зүрхний гажгуудаас хамгийн элбэг тохиолддог.
 5. Уушгины артерит 1-р авиа өргөгдөж салаална.
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
B. Бүх хариулт зөв бол
C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

423. Томуугийн үед бусад амьсгалын замын халдвараас ялгагдах эмнэлзүйн гол шинжүүдийг зөв сонгоно уу?

1. Биеэр цусархаг тууралт гарах
2. Өндөр халуурах
3. Хордлогын шинжүүд тод
4. Өвчин цочмог эхэлж, хурдан тархах
5. Халдвар авснаас хойш өвчний эхний шинжүүд илрэх хүртэлх нууц хугацаа маш богино

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
E. Бүх хариулт зөв бол

424. Хөндийгүй анхдагч дүрс язгуурт аль нь орох вэ?

1. Толбо
2. Гүвдрүү
3. Товруу
4. Сорви
5. Хайрс

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
C. Бүх хариулт зөв бол
D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

425. Ямар үед өтгөн хатах шинж илэрдэг вэ?

1. S гэдэс харьцангуй урт
2. Хэрэглэж буй хүнсний төрөл
3. Гэдэсний гажиг хөгжил
4. Булчин чангарсан үед
5. Халуурах

- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
D. Бүх хариулт зөв бол
E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

426. Бага жинтэй нярай төрөх шалтгаанд юу орох вэ?

1. Хоол тэжээлийн дутагдал
2. Жирэмсэн эхийн өвчлөл
3. Жирэмсэн эхийн тамхидалт
4. Эх чихрийн шижинтэй байх
5. Эх хөдөлгөөн ихтэй байх

- A. Бүх хариулт зөв бол
B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

427. Хүүхдийн автомат рефлексүүдийг нэрлэнэ үү?

1. Уруул цорвойх
2. Атгах
3. Тулгуурын
4. Огих
5. Нүд анивчих

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

428. “Маш хүнд халууралт өвчин” гэж анх ангилагдсан 5 сартай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Тохирох антибиотикийн эхний тунг өгнө.
2. Цусны чихэр багасхаас сэргийлж хүүхдийг эмчил
3. Сайн хөхүүлэхийг зөвлөнө
4. 38,5 хэмээс дээш халуунтай бол парацетамол өгнө
5. Гараа эмчилгээ хийсний дараа эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

429. IgA дутмагшилтай хүүхдэд зонхилон тохиолдох өвчнийг нэрлэнэ үү?

1. Харшлын өвчин
2. Нарийн, бүдүүн гэдэсний шархлаат өвчин
3. Ходоод гэдэсний замын өвчин
4. Ялтсан эс цөөрөх
5. Дэлүү томрох

A. Бүх хариулт зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

430. Ямар үед зулай овойх вэ?

1. Тархины хаван
2. Мэнэн
3. Гавлын дотоод даралт ихсэх
4. Сульдаа
5. Сүрьеэ

A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

431. Шенлейн-Генохын өвчин дараах хүчин зүйлээс хамааралтай

1. Өвөл хаврын улирал
 2. Сургуулийн нас
 3. Архаг голомт
 4. Сэргийлэх тарилга
 5. Харшил өгөх хүнсний зүйл
- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
E. Бүх хариулт зөв бол

432. 2 настай хүүхэд 1 хоног өндөр халуурч, татсан зовиуртай дуудага өгсөн. Хүүхдийг үзхэд таталт намдсан, халуун буурсан, өөр зовиур, эмгэг шинж илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилаж, ямар тусламж үзүүлэх вэ?

1. Аюултай ерөнхий шинжтэй гэж ангилна.
 2. Маш хүнд халууралт өвчин гэж ангилна
 3. Өндөр халуурвал парацетомол өг
 4. Тохирох антибиотикын эхний тунг өг, цусны чихэр багасахаас сэргийлнэ, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 5. эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- A. Бүх хариулт зөв бол
B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

433. Хүүхдийн уушгины голомтот үрэвслийн онцлог шинж юу вэ?

1. Өвчин аажим эхэлсэн үед АЦХ-ын шинж дээрдэж байснаа 7 хоногийн сүүлээр ерөнхий хордлогын шинж дахин илрэх
 2. Цэртэй ханиалгах, амьсгаадах
 3. Дал хооронд ба далны доод хэсэгт тогшилтын авиа бүдгэрэх
 4. Уушгины авиа суларсан эсвэл тодорсон
 5. Шаржигнасан жижиг хөөслөг нойтон хэржигнүүр
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
D. Бүх хариулт зөв бол
E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

434. Вакцин хийлгэсэн хүүхдийн ээжэд юуг сануулах ёстой вэ?

1. Хүүхэд нэг өдөр бие нь тавгүй болж, халуурч болзошгүй
 2. Энэ нь вакцинд дархлаа үүсэж буй хэвийн хариу урвал тул айх хэрэггүй, хүүхдээ сайн хөхүүлж, шингэн сайн уулга.
 3. Хэрэв хүүхэд нэгээс олон хоног халуурвал авчирч үзүүлэх хэрэгтэй.
 4. . Хэрэв хүүхэд вакцин хийлгэсэн өдрөө халуурвал котримоксазол, парацетамол хоёрыг өгөөрэй.
 5. Вакцинд харшил үүсч болзонгүй тул димедрол уулгаарай.
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
B. Бүх хариулт зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

435. Ханиад шуухнаатай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөх вэ?

1. Халуурах

2. Өвчин хүндрэх

3. Амьсгал олшрох.

4. Амьсгал саадтай болох.

5. Хөхөндөө буюу хоолондоо муудах

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. Бүх хариулт зөв бол

C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

436. Синусит буюу дайвар хөндийнүүдийн үрэвслийг оношлохдоо дараахид тулгуурлана:

1. Эмнэлзүйн шинжүүд

2. Дух хацрын ясанд дарах тогшиход хөндүүрлэх

3. Нүүрний рентген зурагт дайвар хөндийд шингэний түвшин илрэх

4. Дайвар хөндийд хатгалт хийх

5. Нянгийн шинжилгээ

A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

B. Бүх хариулт зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

437. Шенлейн-Генохын өвчний үед судасны нэвтрэмж багасгах, цус тогтоох зорилгоор ямар эмийн бэлдмэлийг хэрэглэж болох вэ?

1. Аскорбины хүчил

2. Рутин

3. Аскорутин

4. Хлорт ба глюконат кальцийн уусмал

5. Викасол

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

438. Пиелонефритээр өвдсөн хүүхдэд хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн ямар арга хэмжээ авах вэ?

1. Хоногийн давсны хэрэгцээг 1,5-3 гр. хүртэл хязгаарлана.

2. C, B бүлгийн аминдэм өгнө.

3. Бифидум бактерин эсвэл лактобактерин уулгана.

4. Сэдрэлээс сэргийлэх эмчилгээг 6 сар төгс хийнэ. Эхний 10 хоног антибиотик эсвэл уросептик хэрэглэнэ.2 дахь 10 хоногт ургамал эмчилгээг залгаж хийнэ.3 дахь 10 хоногт завсарлана.

5. Даарч хөрөхгүй байх, задгай усанд орохгүй байхыг зөвлөнө.

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

439. Рахитын улмаас толгойн ясанд гарах өөрчлөлтүүдийг зөв сонгоно уу

1. Дагзны яс зөөлрөх

2. Зулайн ирмэг зөөлрөх

3. Дух чамархайн ясанд булдруу үүсэх

4. Зулай хожуу битүүрэх

5. Зулайн ирмэг овойж, эрт битүүрэх

A. Бүх хариулт зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

440. Мэдрэл үений эмзэгшилтэй хүүхдийн эмчилгээ сэргийлэлтэд дараах орно:

1. Пуринээр баялаг бүтээгдхүүн хязгаарлах

2. Хүчээр хооллохгүй байх

3. Биеийн тамираар хичээллэх

4. Гэнэтийн цочролоос сэргийлэх

5. Шүлтлэг рашаан, давс үе үе хэрэглэх

A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

E. Бүх хариулт зөв бол

441. Верльгофын өвчний эмгэгжамд гойд нөлөөтэй хүчин зүйлсийг нэрлэ.

1. Ясны чөмгөнд ялгаран хөгжөөгүй эсийн хэт төлжилт явагдах

2. VIII хүчин зүйл хомсдох

3. Ялтсан эсийн тоо цөөрөх

4. Захын цусанд ялтсан эсийн задрал ихсэх

5. Цус гоожих

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

E. Бүх хариулт зөв бол

442. Ганболд, 8 сартай, 9 кг жинтэй, алга цайсан, Хөхөө хөхөхдөө хөлөрдөг, булчин сул, сарпингийн эрхийн шинжтэй. Хоногт 5 удаа хөхөө хөхдөг, 200 гр

бантан, 200 гр каш иддэг, цай боорцогтой 1 удаа иддэг, өөр хоол өгдөггүй. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Ангил. Эмчил. Ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Цус багадалт. Рахит. Хооллолтын бэрхшээлтэй.- гэж ангилна.
2. Төмрийн сироп 2 мл-ээр 14 хоног уулгана.
3. Д витамин 50000 нэгжтэй шахмалаас даваа, пүрэв гариг бүрт нийт 7 удаа уулгана.
4. Хөхөө сайн хөхүүлэх, нэмэлт хоолыг 3 удаа идүүлэх ба цайны оронд хярам, жимсний шүүс, буцалсан ус уулгахыг зөвлөнө.
5. Давтан үзлэгт 5 хоноод ирэх.

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

443. Зүрхний дотор бүрхүүлийн фибраэластозын үед хүүхэд төрсний дараах эхний сард илрэх шинжүүдээс дурьдана уу.

1. амьсгаадах
2. өсөлт саатах
3. амьсгалын халдвараар байнга өвчлөх
4. гуурсан хоолой бөглөрөх
5. зүрхний дутагдлын шинжүүд

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол

B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

444. Ходоодны архаг үрэвслийн үндсэн шинжүүдийг заа.

1. Өлөн үед өвдөлт илрэх.
2. Ходоод дүүрэх, цардах, юм идсэний дараа аюулхай орчим өвдөх
3. Хэвлийг тэмтрэхэд баруун хавирга дор хөндүүрлэх
4. Хэвлийг тэмтрэхэд аюулхай орчим хүндүүрлэх.
5. Керын шинж эерэг байх.

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

445. Гаждал цохиулалтын эмчилгээнд яаралтай хэрэглэх эмийн бэлдмэлүүдэд дараах

1. Зүрх, амьсгалын үйл ажиллагааг сайжруулах бэлдмэл
2. Адренерги үйлчилгээтэй бэлдмэл
3. Кортикостероид
4. Гистамины эсрэг эм
5. Фосфодиэстеразын саатуулуур

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. Бүх хариулт зөв бол

- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

446. Сувд, 14 хоногтой, 3,6 кг жинтэй, арьсан дээр ганц нэг идээт цэврүү гарсан. Хоногт 9 удаа хөхөө хөхдөг. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Ангил. Эмчил.

1. Хэсэг газрын нянгийн халдвар. Хооллолтын бэрхшээлгүй.-гэж ангилна.
2. Хэсэг азрын халдварыг гэрээр эмчлэхийг эхэд зааж өгнө.
3. Тохирох антибиотыг уулгана.
4. Гэрээр нярайг хэрхэн асрах талаар зааж өгнө.
5. 2 хоноод давтан үзнэ.

- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

447. Шенлейн-Генохын өвчний сэдрэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

1. архаг голомтыг эмчлэх
2. даарах, халууцах, харшил төрүүлэх хүнсний зүйл хэрэглэхээс зайлсхийх
3. харшимтгай бол урьдчилан сэргийлэх тарилга хийлгэхээс өмнө харшлын эсрэг эм уулгах
4. аспирын эмчилгээ хийх
5. гепарин бага тунгаар хэрэглэх

- A. Бүх хариулт зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

448. Улаанууд өвчний үндсэн шинжүүдийг нэрлэ:

1. Дагзны, хүзүүний арын тунгалгын зангилаа томрох
2. Арьсан дээр цайвар ягаан, жижиг толбон тууралт их биеийн ар хэсгээр давамгайлан гарах, туураолт нь хоорондоо нийлэх хандлагагүй.
3. Тууралт 2-3 хоногийн дараа үл мөргүй арилах.
4. Толбон гүвдрүүт тууралт нь хоорондоо нийлэх хандлагатай
5. Тууралтын 3 дахь өдрөөс нүүрний арьснаас эхлэн арьс гуужин нөсөөжилт үүснэ.

- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

449. Нярайн тархины онцлог

1. Харьцангуй том хэмжээтэй
2. Тархины атираа намхан
3. Тархины ховил өнгөц
4. Тархины жижиг ховилууд цөөн
5. Ховдлууд том

- A. Бүх хариулт зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

450. 2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийг үнэлж ангилахдаа эхлээд аюултай ерөнхий шинжүүдийг хэрхэн асууж шалгах вэ?

1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу
2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу
3. Хүүхэд татсан уу
4. Унтаарсан буюу ухаангүй байна уу
5. Цээж хонхолзож байна уу

- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

451. 2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийг үнэлж ангилахдаа аюултай ерөнхий шинжүүдээс ямар шинжийг ажиглах ёстой вэ?

1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу
2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу
3. Хүүхэд татсан уу
4. Унтаарсан буюу ухаангүй байна уу
5. Цээж хонхолзож байна уу

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

452. Баруун уушгины доод дэлбэнгийн үрэвслийн онцлог шинж юу вэ?

1. Өвчин гэнэт эхэлж, өндөр халуурах
2. Толгой өвдөж, биеийн байдал дордох
3. Өвчний эхлэл үед баруун цавь, хүйс орчмоор өвдөх
4. Бөөлжих
5. Гэдэс дүүрэх, суулгах

- A. Бүх хариулт зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

453. Бөөрний түүдгэнцрийн цочмог үрэвслийн тодорхойлолтод тохирохыг зөв сонгоно уу.

1. Стрептококкоор үүсгэгдсэн хамар залгиурын үрэвслийн дараа 10 гаруй хоногийн дараа өвөл, хаврын үед ихэвчилэн тохиолдоно
2. Ихэнхидээ сургуулийн бага насныханд тохиолдоно
3. Хөвгүүд охидоос 2 дахин өвчилнө

4. Сургуулийн насны охид 5 дахин илүү өвчилнө
5. Шээсний замын гаж хөгжлийн суурин дээр илүүтэй үүснэ

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
D. Бүх хариулт зөв бол
E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

454. “Шингэн их алдалттай суулгалт” гэж ангилагдсан 9 сартай 9 кг жинтэй хүүхдэд ямар хэмжээний рингер лактатын уусмалыг, хэрхэн дуслаар хийх вэ?

1. 6 цагийн турш 900 мл буюу 100 мл/кг жинд Рингер лактатын уусмал судсаар дусаана
2. Эхний 1 цагт 270 мл буюу 30 мл/кг Рингер лактатын уусмал судсаар дусаана
3. Дараагийн 5 цагт 630 мл буюу 70 мл/кг Рингер лактатын уусмал судсаар дусаана
4. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг 4 цагийн турш уулган.
5. 4 цагийн турш 120 мл/кг жинд тооцоолон дуслаар шингэн юүлнэ.

A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
C. Бүх хариулт зөв бол
D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

455. Холбогч эдийн түгээмэл үрэвслийн эхлэл үед илрэх эмнэлзүйн ерөнхий шинжүүдийг нэрлэнэ үү.

1. Шалтгаангүй ядрах
2. Хөдөлгөөн сулрах
3. Турж эцэх
4. Хоолонд дургүйлхэх
5. Антибиотик, үрэвслийн эсрэг эмчилгээнд халууралт намдахгүй байх

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
D. Бүх хариулт зөв бол
E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

456. 6 сар хүрээгүй хүүхдэд А аминдэмийг ямар тунгаар , ямар заалтаар өгдөг вэ?

1. 50000 нэгжтэй цагаан капсулаас нэгийг эсвэл 100000 нэгжтэй хөх капсулын талыг (3 дусал) өгнө.
2. А аминдэмийн улаан капсулаас 1 ширхэгийг өгнө.
3. Хүнд тураал буюу хүнд цус багадалт гэсэн заалтаар эсвэл улаанбурхан гэж ангилагдсан хүүхдэд А аминдэм уулгана.
4. А аминдэмийн хөх капсулаас 1 ширхэгийг өгнө.
5. Эрүүл ч гэсэн 6 сар тутамд өгнө.

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

457. Хамраас цус гоожих үед яаралтай үзүүлэх арга хэмжээ авна уу

1. Толгойг гэдийлгэж, хамарт хүйтэн жин тавих

2. Адреналин, эфедрин, аскорбины хүчил зэрэг цус тогтоохуусмалаар норгосон чихээс хамарт хийх

3. Хлорт кальци, кальци глюконат, аскорбины хүчил, викасол тарих

4. Гистамины эсрэг ба дааврын бэлдмэл хэрэглэх

5. Хүчилтөрөгч өгөх

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

458. 6 сартай хүүхэд ханиалгаж байгаад цэрээр бөөлжсөн. Эх нь түүнд эм уулгах гэсэн чинь дахин бөөлжиж эмээ гаргасан тул хөхийг нь хөхүүлээд унтуулжээ. Шөнө давтан бөөлжөөгүй. Өглөө хүүхэд сэрээд ханиалгахдаа дахин бөөлжсөн байна. Хүүхдийг үзэхэд амьсгал минутанд 42, цээж хонхозоогүй, хяхтнаа амьсгалгүй, халуураагүй, суулгаагүй, чихний өвчин байхгүй, өөр зовиур, эмгэг шинж илрээгүй. Хүүхдийг хэрхэн үнэлж, ангилах вэ?

1. Уусан бүхнээ бөөлжиж буй тул “Аюултай ерөнхий шинжтэй” гэнэ.

2. Хөхний сүүгээ бөөлжөөгүй тул аюултай ерөнхий шинжгүй гэнэ.

3. Аюултай ерөнхий шинжтэй, ханиалгасан тул “Уушгины хүнд хатгалгаа” гэнэ.

4. Аюултай ерөнхий шинжгүй, ханиалгасан, амьсгал олшроогүй, цээж хонхозоогүй, хяхтнаа амьсгалгүй тул “Ханиад шуухнаа” гэж ангилна.

5. Аюултай ерөнхий шинжгүй, ханиалгасан, амьсгал олшрирсон тул “Уушигны хатгалгаагүй ханиад шуухнаа” гэж ангилна.

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

459. Маш хүнд халууралт гэж ангилсан хүүхдэд өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Үүсгэгчийн эсрэг тохирох эмийн эхний тунг өгнө

2. Цусны сахар багсахаас сэргийлж эмчилнэ. 38,5 хэмээс дээш халуунтай бол парацетамолын нэг тунг өгнө.

3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

4. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног уулгана.

5. Парацетамолыг халуун бууруулахаар 6 цаг тутам уулгахыг зөвлөнө

A. Бүх хариулт зөв бол

B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Е. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

460. Халуурч буй хүүхдэд улаанбурханы ямар шинжүүдийг ажиглах ёстой вэ?

1. Түгээмэл тууралт.
2. Ханиалга.
3. . Нус гойжих.
4. Нүд улайх.
5. Халуурах

А. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

В. Зөвхөн 4-р хариулт зөв бол

С. Бүх хариулт зөв бол

Д. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

Е. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

461. Нярай хүүхдийн зүрхний байрлал?

1. Th6-Th9 түвшинд
2. Хөндлөн байрлалтай
3. Дагуу байрлалтай
4. Th4- Th8 түвшинд
5. Ташуу байрлалтай

А. Зөвхөн 4-р хариулт зөв бол

В. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

С. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Д. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

Е. Бүх хариулт зөв бол

462. Мальабсорбцийн хамшинжийн шалтгаан юу вэ?

1. Гэдэс тайрагдах
2. Нарийн, бүдүүн гэдэсний архаг үрэвсэл
3. Нойр булчирхайн үрэвсэл
4. Антибиотик удаан хэрэглэх
5. Кроны өвчин

А. Зөвхөн 4-р хариулт зөв бол

В. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

С. Бүх хариулт зөв бол

Д. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Е. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

463. Дунд чихний цочмог үрэвслийн үед эмнэлзүйд илрэх гол шинжүүдийг нэрлэнэ үү:

1. Халуурч, сульдах
2. Нэг хэсэг хугацаанд тасралтгүй чарлах
3. Унтаж чадахгүй, уйлах
4. Хөхөх үедээ үе үе больж уйлах
5. Хамар битүүрэх

А. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

В. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

Д. Бүх хариулт зөв бол

Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

464. Нярай хөхүүл хүүхдийн хоол боловсруулах эсэгийн идэвх сул, хэмжээ бага учраас хөндийн хоол боловсруулалт давамгайлна.

А. Зөв, Зөв, Буруу

В. Зөв, Зөв, Зөв

С. Буруу, Зөв, Буруу

Д. Буруу, Буруу, Буруу

Е. Зөв, Буруу, Буруу

465. Хүүхдийн бөөр илүүдэл шингэнийг түргэн ялгаруулдаг тул шээсний хувийн жин бага байдаг.

А. Зөв, Зөв, Зөв

В. Буруу, Зөв, Буруу

С. Буруу, Буруу, Буруу

Д. Зөв, Буруу, Буруу

Е. Зөв, Зөв, Буруу

466. Бөөр нь биологийн идэвхт бодис ялгаруулдаг тул бөөрний эмгэгийн үед даралт ихсэх, цус багадах, цус бүлэгнэлт буурах зэрэг шинж илэрдэг.

А. Зөв, Зөв, Буруу

В. Зөв, Зөв, Зөв

С. Буруу, Зөв, Буруу

Д. Зөв, Буруу, Буруу

Е. Буруу, Буруу, Буруу

467. Хүүхдийн бөөрний цусан хангамжийн ихэнх хэсэг нь тархилаг давхаргаар өнгөрдөг тул бөөрний тархилаг ба холтослог давхаргын зааг муу ялгардаг.

А. Буруу, Буруу, Буруу

В. Зөв, Зөв, Зөв

С. Зөв, Зөв, Буруу

Д. Зөв, Буруу, Буруу

Е. Буруу, Зөв, Буруу

468. Нас ахих тутам тэнэгч мэдрэлийн зохицуулга сайжрах учраас зүрхний цохилт олширно.

А. Зөв, Буруу, Буруу

В. Зөв, Зөв, Буруу

С. Буруу, Буруу, Буруу

Д. Зөв, Зөв, Зөв

Е. Буруу, Зөв, Буруу

469. Хорей өвчний үед албадмал, эмх замбараагүй хөдөлгөөн илэрдэг учраас хүүхэд “сахилгагүй” нэр авдаг.

А. Зөв, Буруу, Буруу

В. Зөв, Зөв, Буруу

С. Зөв, Зөв, Зөв

Д. Буруу, Зөв, Буруу

Е. Буруу, Буруу, Буруу

470. Ургийн үед бөөрний эргэх үйл хямарснаас бөөрний байршлын гажиг үүснэ.

A. Буруу, Зөв, Буруу

B. Зөв, Буруу, Буруу

C. Зөв, Зөв, Буруу

D. Зөв, Зөв, Зөв

E. Буруу, Буруу, Буруу

471. Хүүхдийн бөөрний тунгалгийн судас, гэдэсний тунгалгийн судастай нягт холбоотой байдаг тул гэдэсний халдвар бөөрөнд дамжих боломжтой.

A. Буруу, Зөв, Буруу

B. Зөв, Зөв, Зөв

C. Зөв, Буруу, Буруу

D. Буруу, Буруу, Буруу

E. Зөв, Зөв, Буруу

472. Хүүхдийг их юм мэдүүлэх гэж шахах нь хортой яагаад гэвэл тархи туйлдан ядарч хүүхэд нойр, хоолондоо муудаж цаашилбал мэдрэл-сэтгэхүйн эмгэг ч үүсч болно.

A. Буруу, Буруу, Буруу

B. Зөв, Зөв, Буруу

C. Зөв, Буруу, Буруу

D. Зөв, Зөв, Зөв

E. Буруу, Зөв, Буруу

473. Ясжилтын цэг үүстэл хөндийт яс диафизийн төгсгөлийн мөгөөрсөн эдээс урган уртасна.

A. Буруу, Буруу, Буруу

B. Зөв, Зөв, Зөв

C. Буруу, Зөв, Буруу

D. Зөв, Буруу, Буруу

E. Зөв, Зөв, Буруу

474. Төмөр дутлын цус багадалтын үед ферритиний хэмжээ хэдээс доош байх вэ?

A. 30 нг/мл

B. 50 нг/мл

C. 10 нг/мл

D. 40 нг/мл

E. 20 нг/мл

475. Тураалын II зэргийн үед арьсан доорх өөхөн эд хэрхэн өөрчлөгдөх вэ?

A. Нүүрнээс бусад хэсэгт нимгэрсэн байна

B. Хэвлий, чээжинд арилж, мөчдөөр эрс багассан

C. Нүүрэнд арилж, хэвлий чээжинд нимгэрсэн

D. Нүүр, мөчдөөр нимгэрч, бусад хэсэгт хэвийн байна

E. Бүх биеийн өөхөн давхарга арилна

476. Гүйцэт нярайн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

A. 600 мг

B. 2600 мг

C. 122 мг

D. 242 мг

E. 400 мг

477. 13 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

- A. 122 мг
- B. 400 мг
- C. 600 мг
- D. 242 мг
- E. 2600 мг

478. Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмөр сэлбэх чадвар хэдээс дээш болох вэ?

- A. 83 мкмоль/л
- B. 63 мкмоль/л
- C. 43 мкмоль/л
- D. 53 мкмоль/л
- E. 23 мкмоль/л

479. Тураалын II зэрэгтэй хүүхдийг хэдэн удаа хооллох вэ?

- A. 9
- B. 6
- C. 5
- D. 7
- E. 8

480. 5 настай хүүхдийн гемоглобинд агуулагдах төмөр нийт төмрийн хэдэн хувийг эзлэх вэ?

- A. 72
- B. 73
- C. 55
- D. 79
- E. 70

481. Тураалын II зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

- A. 60-50 ккал/кг
- B. 80-65 ккал/кг
- C. 110-130 ккал/кг
- D. 100-95 ккал/кг
- E. 90-85 ккал/кг

482. Тураалын II зэргийн үед жингийн алдагдал ямар байх вэ?

- A. 10-15%
- B. 40-45%
- C. 11-20%
- D. 30-40%
- E. 21-30%

483. Тураалын III зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

- A. 80-65 ккал/кг
- B. 60-50 ккал/кг
- C. 90-85 ккал/кг
- D. 110-130 ккал/кг
- E. 100-95 ккал/кг

484. 2 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

- A. 122 мг

- B. 600 мг
- C. 242 мг
- D. 400 мг
- E. 2600 мг

485. Төмөр дутлын цус багадалтын үед 6 хүртэлх насны хүүхдэд Hb хэмжээ хэдээс доош байх вэ?

- A. 130 г/л
- B. 110 г/л
- C. 100 г/л
- D. 140 г/л
- E. 120 г/л

486. Тураалын I зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

- A. 90-85 ккал/кг
- B. 60-50 ккал/кг
- C. 80-65 ккал/кг
- D. 100-95 ккал/кг
- E. 110-130 ккал/кг

487. Хоол хүнсэн дэх төмрийн хэдэн хувь нь шимэгддэг вэ?

- A. 10
- B. 15
- C. 20
- D. 1
- E. 2

488. Үнээний сүүг хоногт хэдэн литрээс илүү хэрэглэхэд хүүхдэд төмрийн дутагдал үүсч болох вэ?

- A. 2
- B. 0.5
- C. 3
- D. 1
- E. 0.1

489. Рахитын эхлэл үед хүүхдэд өгөх D-аминдэмийн тун ямар байх вэ?

- A. 2000-5000 ME/хоног
- B. 200000-400000 ME/курс
- C. 500-600 ME/хоног
- D. 50-100 ME/кг
- E. 100-200 ME/кг

490. Төмөр дутлын цус багадалтын үед улаан эсийн дундаж эзлэхүүн (MCV) хэдээс доош байх вэ?

- A. 90 фл
- B. 60 фл
- C. 70 фл
- D. 80 фл
- E. 90 фл

491. Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмрийн хэмжээ хэдээс доош байх вэ?

- A. 34 мкмоль/л

- В. 10 мкмоль/л
- С. 14 мкмоль/л
- Д. 4 мкмоль/л
- Е. 24 мкмоль/л

492. Хүнд тураалтай хүүхдийн хоолонд аль нь илүү тохирох вэ?

- А. Өтгөн зутан
- В. Хөхний сүү
- С. Шингэн бантан
- Д. Үнээний сүү
- Е. Хярам

493. Хүнд тураалтай хүүхдэд хоногт нэмж өгөх магнийн хэмжээ хэд вэ?

- А. 3.0-4.0 ммоль/кг
- В. 7.0-8.0 ммоль/кг
- С. 5.0-6.0 ммоль/кг
- Д. 1.0-2.0 ммоль/кг
- Е. 0.4-0.6 ммоль/кг

494. Төмөр дутлын цус багадалтын үед хүүхдэд өгөх төмрийн хэмжээ ямар байх вэ?

- А. 3-5 мг/кг
- В. 1-2 мг/кг
- С. 0.5-0.8 мг/кг
- Д. 6-8 мг/кг
- Е. 8-10 мг/кг

495. D-аминдэмийн дутагдлын үед ясанд гарах өөрчлөлтийг заана уу?

- 1. Эпифизд ясны сийрэгжилт явагдана
- 2. Метафизд остеоид эд хэт их ургана
- 3. Өсөлтийн зон өргөснө
- 4. Мөгөөрсөн эд хайлна
- 5. Коллагены бүтэц өөрчлөгдөнө
- А. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- В. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- С. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- Д. Бүх хариулт зөв бол
- Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

496. Рахитын ид үед булчингийн тонус суларсныг илтгэх шинжүүдийг заана уу?

- 1. Хөдөлгөөний идэвх сулрах
- 2. Үе мөч нь уян, нугарамхай болох
- 3. Гэдэс цардаих
- 4. Кифоз үүсэх
- 5. Шүд хожуу ургах
- А. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- В. Бүх хариулт зөв бол
- С. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- Д. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- Е. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

497. Тураалтай хүүхдэд гарах өөрчлөлтийг заана уу?

1. Халдвар далд бүдэг явцтай
2. Төв мэдрэлийн тогтолцооны сэрэл өөрчлөгдөнө
3. Ходоод-гэдэсний хоосрох үйл хямарна
4. Олдмол рефлекс алдагдана
5. Төрөлхийн рефлекс алдагдана

A. Бүх хариулт зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

498. Дараахаас аль нь хүүхдийн тураалын шалтгаан болох вэ?

1. Хромосомын гажиг
2. Жирэмсэн эх өлсөх
3. Целиаки өвчин
4. Ургийн хүчилтөрөгчгүйдэл
5. Жирэмсэн эхийн хорт зуршил

A. Бүх хариулт зөв бол

B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

C. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

499. Тураалын III зэрэгт ямар шинж тохирохгүй вэ?

1. Салст бага зэрэг цайвар
2. Жингийн алдагдал 20-30%
3. Чулицкийн индекс 10-15
4. Мэдрэл сэтгэцийн хөгжил насандаа тохирсон
5. Маразмын шинж

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

500. Дараах шалтгаанаас аль нь төмөр алдагдахтай холбоотой вэ?

1. Мелена
2. Гематури
3. Метрорраги
4. Гельминтоз
5. Мальабсорбци

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

501. Дараах шалтгаанаас аль нь хүнсээр авах төмөр дутахтай холбоотой вэ?

1. Нэмэгдэл хоолонд хожуу орох

2. Ургамлын гаралтай хоол удаан хэрэглэх

3. Тэжээвэр хооллолт

4. Үнээний сүү ихээр хэрэглэх

5. Мөнгөн усны архаг хордлого

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

502. Бага насны хүүхэд D-аминдэмийн дутагдалд орох шалтгааныг заана уу?

1. Нар, салхинд бага гаргах

2. Каш, ногоо их өгөх

3. Нэмэлт хоолонд хожуу оруулах

4. Дутуу төрөх

5. Бага жинтэй төрөх

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

503. Тураалын I зэргийн үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. Орчиндоо сонирхолгүй

2. Гэрэл асах, дуу чимээ гарахад цочиж сэрэх

3. Чулицкийн индекс 0-10

4. Арьс салст бага зэрэг цайвар

5. Хөхөө хөхөхдөө хөлрөх

A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

504. Төмөр дутлын үед гарах өөрчлөлтийг заана уу?

1. Төмрийн тээвэрлэлт хямарна

2. Гемоглобины нийлэгжилт хямарна

3. Метафизд остеоид эд хэт их ургана

4. Улаан эсийн Hb-аар хангагдах явдал хямарна

5. ДНХ-ийн нийлэгжилт хямарна

A. Зөвхөн 4-р хариулт зөв бол

B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. Бүх хариулт зөв бол

505. Төмөр дутлын цус багадалтын үед мэдрэлийн зүгээс ямар өөрчлөлт илрэх вэ?

1. Чих шуугих

2. Нүд бүртэлзэх

3. Гаж үнэрт дуртай болох
4. Хоолонд дургүй болох
5. Элэг томрох
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

506. Тураалын I зэрэгт аль шинж тохирохгүй вэ?

1. Гэдэс цардгар
2. Амны салт тод ягаан өнгөтэй
3. Арьсан доорх өөхөн эд цээжинд арилсан
4. Биеийн жин 11-20% буурсан
5. Хэвлий орчим арьс үрчийнэ
- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

507. Хүнд тураалтай хүүхдэд эмчилгээний эхний өдрүүдээс нэмж өгч болохгүй зүйлийг заан уу?

1. Кали
2. Натри
3. Аминдэм
4. Төмөр
5. Магни
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

508. Тураалын үед хүүхдэд дараахаас аль нь илрэх вэ?

1. Өөхлөг давхарга өөрчлөгдөх
2. Халдварт өртөмхий болох
3. Жин буурах
4. Мэдрэл-сэтгэцийн хөгжил хоцрох
5. Булчингийн хүчдэл сулрах
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

509. Бромгексины олон улсын нэршил

1. Амбrolитик
2. Лизомуцин
3. Ацетицистейн

- 4. Бромгексин гидрохлорид
- 5. Акрихин
- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

510. Рахитын өвөрмөц эмчилгээнд аль нь хамаарах вэ?

- 1. Агаарт сайн гаргах
- 2. Массаж хийх
- 3. Кальциар баялаг хоол өгөх
- 4. Холекальциферол өгөх
- 5. Зөв хооллох
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

511. Тураалтай маш сул дорой хүүхдэд тэжээлийн холимгийг ямар аргаар өгөх вэ?

- 1. Дусаагуур
- 2. Халбага
- 3. Тариур
- 4. Угж
- 5. Аяга
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

512. 2 хүртэлх насны хүүхэд уушгины цочмог үрэвслээр эндэх шалтгаан юутай холбоотой вэ?

- 1. Уушгины завсрын эдийн хөгжил сул
- 2. Цусны судсаар баялаг
- 3. Хялгасан судас, тунгалгийн ховил өргөн
- 4. Уян эд бүрэн хөгжөөгүй
- 5. Цулцангийн хөгжил эрчимтэй явагдах
- A. Бүх хариулт зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

513. Рахитаас урьдчилан сэргийлэх зорилгоор D-аминдэмийг ямар тунгаар хэрэглэх вэ?

- 1. 50 мкг/хоног
- 2. 10 мкг/хоног

3. 100 МЕ/хоног
4. 500 МЕ/хоног
5. 100 мкг/хоног
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

514. Кальци, фосфорын солилцоонд D-аминдэмийн аль хэлбэр илүү идэвхтэй нөлөөлөх вэ?

1. 25-гидрохолекальциферол
2. 1.25-дигидрохолекальциферол
3. 1.25-холекальциферол
4. 24,25-дигидрохолекальциферол
5. 25-дигидроксихолекальциферол
- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

515. Төмөр дутлын цус багадалтын үед ямар шинж илрэх вэ?

1. Ядрамтгай болох
2. Толгой өвдөх
3. Хэлний хөхлөг арилах
4. Өтгөн хатах
5. Элэг томрох
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

516. Тураалтай хүүхдийг хооллох зарчимд аль нь тохирохгүй вэ?

1. Чихэрлэг хоол өгөх
2. Кали нэмж өгөх
3. Магни нэмж өгөх
4. Натри нэмж өгөх
5. Аминдэм нэмж өгөх
- A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

517. Рахитын эхлэл үед шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?

1. Гипокальциеми
2. Гипофосфатеми
3. Метаболик алкалоз

- 4. Нормокальциеми
- 5. Шүлтлэг фосфатаз буурна
- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

518. Тураалын II зэргийн үед ямар шинж тэмдэг илрэхгүй вэ?

- 1. Хөдөлгөөн-сэтгэцийн хөгжил сул
- 2. Хэвлий цардгар
- 3. Өндрийн хоцрогдол 2-4 см
- 4. Маразмын шинж
- 5. Чулицкийн индекс 0-10
- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

519. Хөнгөн хэлбэрийн рахитын үед гарах өөрчлөлтийг заана уу

- 1. Дотор эрхтний зүгээс өөрчлөлт илэрнэ
- 2. Мэдрэлийн тогтолцооны зүгээс өөрчлөлт илэрнэ
- 3. Цус багадалт илэрнэ
- 4. Ясанд өөрчлөлт илрэхгүй
- 5. Сэтгэц-хөдөлгөөний хөгжил саатна
- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. Бүх хариулт зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

520. Рахитын ид үед ясанд гарах өөрчлөлтөнд аль нь хамаарах вэ?

- 1. Яс зөөлрөх (остеомалыци)
- 2. Ясны зөөлөн эд ургах (остеоид гиперплази)
- 3. Краниотабес
- 4. Caput quadratum
- 5. Улаан дермографизм
- A. Бүх хариулт зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

521. Квашиоркорын үед арьс, салстанд гарах өөрчлөлтийг заана уу?

- 1. Битотын толбо
- 2. Шалбархай
- 3. Нөсөөтөл ихэссэн
- 4. Шүүдэстэй шархалт
- 5. Сувдан хэлхээ

- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

522. Төмөр дутлын цус багадалт ямар хамшинжээр илрэх вэ?

- 1. Хучуур эдийн
- 2. Зүрх судасны
- 3. Мэдрэл сульдлын
- 4. Хоёрдогч дархлаа дутлын
- 5. Булчингийн

- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. Бүх хариулт зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

523. Шуугиант амьсгалтай хатгалгаагүй ханиад шуухинаа ангилсан 23 сартай хүүхдэд өгөх зөвлөгөө

- 1. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар эмнэлэгт хэвтүүл
- 2. хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт, ханиалгыг эмчил
- 3. гуурс тэлэгч эм өг
- 4. хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
- 5. хэрэв сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүл

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

524. D-аминдэмийн хордлогын үед хэрэглэх эм бэлдмэлийг заана уу?

- 1. А-аминдэм
- 2. Фенобарбитал
- 3. Холестирамин
- 4. Преднизолон
- 5. Альмагель

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

525. Төмөр дутлын цус багадалтын үед зүрх-судасны зүгээс ямар шинж илрэх вэ?

- 1. Зүрхний цохилт олширох
- 2. Цусны даралт буурах
- 3. Зүрхний хил томрох
- 4. Ядрамтгай болох
- 5. Элэг томрох

- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- E. Бүх хариулт зөв бол

526. Тураалын II зэргийн үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

- 1. Цочромхой
- 2. Хэвлий цардгар
- 3. Дотор эрхтний зүгээс өөрчлөлт гарна
- 4. Чулицкийн индекс 0-10
- 5. Маразмын шинж илэрнэ

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

527. Дараах шалтгаанаас аль нь төмрийн нөөц багатай төрсөнтэй холбоотой вэ?

- 1. Эх нь жил дараалан төрөх
- 2. Дутуу төрөх
- 3. Перинатал үедээ цус алдах
- 4. Архаг халдварт өвчин
- 5. Үнээний сүү ихээр хэрэглэх

- A. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- B. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

528. Тураалын урьдчилан сэргийлэлтэнд аль нь хамаарах вэ?

- 1. Халдвараас хамгаалах
- 2. Нэмэгдэл хоолонд цагт нь оруулах
- 3. Жирэмсний хяналтыг сайжруулах
- 4. Суурь өвчнийг цаг тухайд нь эмчлэх
- 5. Хүүхдийг 2 нас хүртэл хөхний сүүгээр хооллох

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. Бүх хариулт зөв бол
- D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

529. Хүүхэд тураалд ороход нөлөөлөх гадаад шалтгааныг заана уу?

- 1. Халдвар
- 2. Өлсгөлөн
- 3. Эмийн хордлого
- 4. Анхдагч дархлаа дутал
- 5. Гаж хөгжлүүд

- A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

В. Бүх хариулт зөв бол

С. Зөвхөн 4-р хариулт зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Е. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

530. В12-аминдэм дутагдахад ямар өөрчлөлт гарах вэ

1. Төмрийн тээвэрлэлт хямарна

2. ДНХ-ийн нийлэгжилт хямарна

3. Гемоглобины нийлэгжилт хямарна

4. Улаан эсийн хуваагдал алдагдана

5. Гэдсэнд кальцийн шимэгдэлт алдагдана

А. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

В. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

531. Хүүхдийн тэжээлийн архаг хямрал аль насанд илүү тохиолдох вэ?

1. Нярай үе

2. Бага нас

3. Сургуулийн өмнөх

4. Хөхүүл нас

5. Өсвөр нас

А. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

В. Бүх хариулт зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

Е. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

532. Хүүхдийн тураалд хүргэх шалтгааныг заана уу?

1. Хүрээлэн байгаа орчны хортой нөлөө

2. Ниман-Пикийн хамшинж

3. Муковисцидоз

4. Галактоземи

5. Төв мэдрэлийн тогтолцооны эмгэг

А. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

В. Зөвхөн 4-р хариулт зөв бол

С. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

Е. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

533. Тураалын эмгэгжамтай холбоотой гарах өөрчлөлтийг заана уу?

1. Уургийн задрал давамгайлна

2. Бодисын солилцооны хүчилшил

3. Эсийн задрал эхэлнэ

4. Гликогены нөөц буурна

5. Улаан эсийн задрал ихэснэ

А. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

В. Зөвхөн 4-р хариулт зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

534. Төмөр дутлын цус багадалтын эмчилгээнд аль нь хамаарах вэ?

1. Холекальциферол өгөх
2. 2 валенттай төмөр агуулсан бэлдмэл хэрэглэх
3. Кальциар баялаг хоол өгөх
4. Аскорбины хүчил хамт хэрэглэх
5. B6, B12-аминдэм хамт хэрэглэх

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

C. Бүх хариулт зөв бол

D. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

535. Рахитын үед ясны рентген зурагт ямар өөрчлөлт ажиглагдаж болох вэ

1. Остеопороз
2. Метафиз өргөсөх
3. Эпифиз хавтгайрах
4. Яс “ногоон мөчир” хэлбэрээр хугарна
5. “Хуурамч” хугарал үүснэ

A. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

D. Бүх хариулт зөв бол

E. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

536. D-аминдэмийн дутагдлын улмаас үүсэн рахитыг ямар эмгэгтэй ялган оношлох вэ?

1. Удамшлын гипофосфатеми
2. Дебре-де-Тони-Фанкони хамшинж
3. Витамин D хамааралтай I хэлбэрийн рахит
4. Фосфат диабет
5. Osteogenesis imperfecta

A. Бүх хариулт зөв бол

B. Зөвхөн 4-р хариулт зөв бол

C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

D. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

E. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

537. Рахит эдгэрэх үед ямар шинж тэмдэг ажиглагдах вэ?

1. Булчингийн тонус хэвийн болно
2. Цусан дахь кальцийн хэмжээ бага байж болно
3. Мэдрэлийн тогтолцооны зүгээс өөрчлөлтгүй болно
4. Анеми илэрч болно
5. Остеомаляцын шинж илэрнэ

A. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

B. Бүх хариулт зөв бол

C. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

D. Зөвхөн 4-р хариулт зөв бол

Е. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

538. Цочмог явцтай рахит дараах байдлаар илэрнэ

1. Яс зөөлрөх шинжүүд давамгайлна
2. Цусанд фосфорын хэмжээ буурна
3. Мэдрэлийн тогтолцооны зүгээс шинж тэмдэг тод илэрнэ
4. Яс ургах шинжүүд давамгайлна
5. Хордлогын шинж тэмдэг давамгайлж илэрнэ

А. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

В. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

С. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

Д. Бүх хариулт зөв бол

Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

539. Аль нь атопийн дерматитын үрэвслийг намдаах даавар агуулаагүй түрхлэг вэ?

А. Элидел (пимекролимус)

В. Авеено

С. Элоком

Д. Цетафил

Е. Клотримазол

540. 6-12 сартай хүүхдэд цитеризиныг ямар тунгаар өгөх вэ?

А. Хоногт нэг удаа 10 мг

В. Хоногт нэг удаа 5 мг

С. Хоногт нэг удаа 0,5 мг

Д. Хоногт нэг удаа 1,0 мг

Е. Хоногт нэг удаа 2,5 мг

541. Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгааныг илрүүлэх шинжилгээг нэрлэ

А. Хамрын салстын шүүрэлд эозинофиль тоолох

В. Өвөрмөц IgE

С. Асуумжийг хянамгай авах

Д. Ерөнхий IgE

Е. Спирографи

542. Атопийн дерматитэд хэрэглэх кортикостероид тосноос хамгийн сул хүчтэй ангилалд орох тосыг нэрлэ:

А. Бетаметазон валерат

В. Триамценолан ацетонид

С. Аклометазон

Д. Метилпреднизолон(адвантан)

Е. Гидрокортизон

543. Хөхүүл насанд ГХБ-ны шалтгаанд юу гол байр эзэлдэг вэ?

А. Хөгц мөөгөнцөр

В. Ургамлын тоос

С. Хоол хүнс

Д. Амьсгалын цочмог халдвар

Е. Гэрийн тоосны хачиг

544. Кларитин нэрээр үйлдвэрлэгддэг антигистамины химийн нэр?

- A. Цитеризин
- B. Дефингидрамин
- C. Лоратадин
- D. Левоцитеризин
- E. Дезлоратадин

545. ГХБ хөдөлсөн үед сальбутамолыг 5 настай хүүхдэд ямар хэмжээгээр өгөх вэ?

- A. 4 мг-аар өдөрт 4 удаа
- B. 3 мг-аар өдөрт 3 удаа
- C. 2 мг-аар өдөрт 3 удаа
- D. 1 мг-аар өдөрт 2 удаа
- E. 4 мг-аар өдөрт 3 удаа

546. Шүүдэст эмзэгшлээс сэргийлэхийн тулд жирэмсний сүүлийн хагаст дараах зүйлийг хэрэглэхгүйг хичээх

- 1. Зөгийн бал
- 2. Шоколад
- 3. Өндөг
- 4. Хоол амтлагч-халуун ногоо
- 5. Амьтны уураг ихээр

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

547. Шүүдэст эмзэгшилтэй хүүхдийн бодисын солилцооны онцлог:

- 1. Ус-давсны солилцоо тогтворгүй
- 2. Ус, натрийг барих хандлагатайгаас хүүхэд хөөнгө, илүү жинтэй байна.
- 3. Өвчний үед шингэн алдах нь хялбархан, жингээ хурдан алддаг.
- 4. Элэгний үйл хямралаас бодисын солилцооны хүчилшил үүсэх хандлагатай
- 5. Цусанд уураг багасах, чихэр, тослог ихсэх, аминдэм болон төмөр зэрэг бичил язгуурын дутагдалд өртөмхий

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол
- D. Бүх хариулт зөв бол
- E. Зөвхөн 4-р хариулт зөв бол

548. Харшлын сорилыг ямар үед тавьж болохгүй вэ?

- 1. Халуурч буй үе
- 2. Харшлын өвчин ид хөдөлсөн үе
- 3. Биеэр түгээмэл тууралттай үе
- 4. Гистамин, лейкотриены эсрэг эм уусан үе
- 5. ДОХ, сүрьеэ

- A. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол
- B. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол
- C. Зөвхөн 4-р хариулт зөв бол
- D. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

Е. Бүх хариулт зөв бол

549. Дараах эмүүдээс аль нь нойрсуулах нөлөөгүй вэ?

1. Кларотадин
2. Цитеризин
3. Телфаст
4. Левоцитеризин
5. Хлорфенирамин

А. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

В. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

С. Зөвхөн 4-р хариулт зөв бол

Д. Бүх хариулт зөв бол

Е. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

550. Суулгалттай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх вэ?

1. Бие нь муудах
2. Хөлрөх
3. Халуурах
4. Уухдаа муу болох
5. Баас цустай болох

А. 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол

В. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

С. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

Д. Бүх хариулт зөв бол

Е. Зөвхөн 4-р хариулт зөв бол

551. Шүүдэст эмзэгшлийг сэдээгч нь дараах хоолноос аль нь байж болох вэ?

1. Үнээний сүү
2. Өндөг
3. Гүзээлзгэнэ
4. Шоколад
5. Хиам

А. 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол

В. 2 ба 4 дугаар хариултууд зөв бол

